



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 13 өдөр

Дугаар 9/460

Хэрлэн сум

Сургалтад хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын санхүү албаны дарга, мэргэжилтэн нарт төрийн сангийн цахим шилжилтийн талаарх цахим сургалтыг 2022 оны 9 дүгээр сарын 26-д зохион байгуулахтай холбогдуулан гарын авлага бэлтгэхэд зориулж 1300.000 (нэг сая гурван зуун мянга) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ